


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 03 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар буюу **эпидемиологийн 1-11 дугаар долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 6 аймагт **805** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 805 тохиолдлын 93% /745/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 7% /60/ нь орон нутагт (Баян-Өлгий /24/, Дорнод /3/, Орхон /6+5/, Өмнөговь /1/, Сэлэнгэ /5/, Төв/16/) бүртгэгдсэн байна.



Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу 211 тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

ЭПИДЕМИОЛОГИЙН **11** ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2025.03.09 - 03.15)

2025 оны эпидемиологийн 11 дугаар долоо хоногт угаарын хийн хордлогын **46** тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 4%-иар, сүүлийн 5 жилийн дунджаас 22%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.




ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **эпидемиологийн 1-11 дугаар долоо хоногт нийт 189** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.


102Эмнэлгийн
тусламж авч буцсан**87**Хэвтэн эмчлүүлж
эдгэрч гарсан**0**

Нас барсан

Эрэгтэй
44%Эмэгтэй
56%

Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 11 дугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **17** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 48 хувиар буурсан байгаа хэдий ч сүүлийн 5 жилийн дунджаас 63 хувиар их байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 11 долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	3	9	12
2	Эмийн хордлого	4	1	5
Нийт		7	10	17

Тухайн долоо хоног химийн бодисын хордлогод **санамсаргүйгээр** өртсөн тохиолдлууд зонхилж байгаа бөгөөд үүний 50%-ийг 0-4 насны хүүхдүүд эзэлж байна. Шалтгааныг авч үзвэл аяга таваг, буйдан угаагч шингэн, белизна зэрэг ахуйн болон цэвэрлэгээний бүтээгдэхүүн болон үнэртэй ус, тосол зэрэг байна. Санаатайгаар буюу амиа хорлох сэдлээр химийн бодис хэрэглэсэн тохиолдлуудыг 20-52 насны хүмүүс эзэлж байна.

-o0o-